

ЖИШИГ НОРМ БОЛОВСРУУЛАХ
АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

06
2019 оны 05 дугаар
сарын 17-ны өдөр

Дугаар АИТ-19/115108/37 Улаанбаатар хот

1. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү "Төмөр замын далан, газар шорооны ажлын төсвийн жишиг норм" боловсруулах ажил гүйцэтгэх гэрээг

Нэг талаас "Монголын төмөр зам" ТӨХК (цаашид "Захиалагч" гэх),

Нөгөө талаас НО75072976 тоот регистрийн дугаартай Базарбиднаа овогтой Баярсайхан (цаашид "Гүйцэтгэгч" гэх), (цаашид хамтад нь "талууд" гэх) нар гэрээнд заасан нөхцөлөөр ажил гүйцэтгэхтэй холбоотой харилцааг зохицуулах үүднээс харилцан тохиролцон байгуулав.

1.2. Энэхүү гэрээгээр Гүйцэтгэгч Төмөр замын далан, газар шорооны ажлын төсвийн жишиг норм боловсруулах ажлыг хийж гүйцэтгэн Захиалагчид хүлээлгэн өгөх, Захиалагч нь тохиролцсон ажлын хөлсийг төлөхтэй холбоотой үүсэх харилцаанд талуудын эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлж зохицуулна.

2. Гэрээний зүйл, гүйцэтгэх ажил

2.1. Гүйцэтгэгч нь Төмөр замын далан, газар шорооны ажлын төсвийн жишиг норм боловсруулах ажлыг (цаашид "Гэрээт ажил" гэх) хугацаанд нь гүйцэтгэж захиалагчийн өмчлөл буюу эзэмшилд шилжүүлнэ.

2.2. Гэрээт ажлын үр дүнд Монгол улсын төмөр замын салбарын хэмжээнд замын далан, газар шорооны ажил хийж гүйцэтгэхэд баримтлах жишиг үнэ, ажлын хэмжээ, зардал, төсвийг тооцох аргачлал эрх зүйн бичиг баримт бий болно.

2.3. Энэхүү гэрээний зүйл нь Төмөр замын далан, газар шорооны ажлын төсвийн жишиг норм боловсруулж, Зам, тээврийн хөгжлийн яамны Шинжлэх ухаан технологийн зөвлөлөөр дэмжүүлэн батлуулах замаар төмөр замын гол шугам, өртөөний замууд, салбар замуудыг шинээр барих, мөн одоо байгаа төмөр замын их засвар, шинэчлэлт, мөн өртөөний замын өргөтгөл шинэчлэлт хийхэд ашиглах нөхцөлийг хангуулахад оршино.

2.4. Гэрээт ажлыг энэхүү гэрээний хавсралтаар батлагдсан ажлын төлөвлөгөөний дагуу гүйцэтгэнэ. Ажлыг гүйцэтгэхдээ гэрээний хавсралтад заасан цар хүрээгээр хязгаарлагдахгүй бөгөөд хууль тогтоомж, дүрэм журамд заасан ажлыг зохих ёсоор бүрэн гүйцэтгэнэ.

2.5. Ажлын гүйцэтгэл нь хууль тогтоомж, дүрэм, заавар, үндэсний болон олон улсын стандартад нийцсэн байх бөгөөд эрх бүхий төрийн байгууллагаар хүлээн зөвшөөрөгдөхүйц байна.

2.6. Ажлын үр дүн гэрээт ажил, ажлын тайлан, эх материал болон бусад холбогдох дагалдах зүйлс нь захиалагчийн эзэмшил өмчид тооцогдоно. Захиалагчийн зөвшөөрөлгүйгээр бүрэн болон хэсэгчлэн хувилах, олшруулах, тараахыг хориглоно.

3. Гэрээний хугацаа

3.1. Ажил гүйцэтгэгч нь ажлыг 2019 оны 05 дугаар сарын 06-ны өдрөөс эхлэн 2019 оны 07 дугаар сарын 17-ны өдрийн дотор гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлж хүлээлгэн өгнө.

3.2. Ажил гүйцэтгэгчийн үйл ажиллагаа, зохион байгуулалт, ажил гүйцэтгэхэд шаардагдах техник тоног төхөөрөмжийн аливаа саатал, эрсдэл, санхүүгийн хүндрэл зэрэг нь ажил гүйцэтгэх хугацааг өөрчлөх буюу хойшлуулах үндэслэл болохгүй.

3.3. Ажлыг хугацаанд нь гүйцэтгээгүй, эсхүл хугацаа хожимдуулж гүйцэтгэсэн нь ажил гүйцэтгэгчид захиалагчийн зүгээс энэ гэрээнд заасан алданги болон торгууль ногдуулах үндэслэл болно.

4. Гэрээт ажлын хөлс

4.1. Гэрээгээр гүйцэтгэх ажлын нийт хөлс 9,400,000 (есөн сая дөрвөн зуун мянга) төгрөг байна.

4.2. Энэхүү гэрээний дагуу төлөх ажлын хөлсний 40 хувьтай тэнцэх хэсгийг гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулснаас хойш ажлын 7 хоногт багтаан төлнө.

4.3. Ажлын хөлсний үлдэх хувь болох 60 хувьтай тэнцэх хэсгийг гэрээт ажлын үр дүнг бүрэн гүйцэтгэж, түүнийг акт үйлдэн хүлээн авснаас хойш ажлын 7 хоногт багтаан гүйцэтгэлээр нь төлнө.

4.4. Захиалагч тал төлбөрийг гүйцэтгэгч компанийн ХУДАЛДАА ХӨГЖИЛ банкны 403108784 тоот дансанд шилжүүлсэн өдрийг ажлын хөлсийг төлсөн өдөрт тооцно.

5. Захиалагчийн эрх, үүрэг

5.1. Гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлэхийг Гүйцэтгэгчээс шаардах;

5.2. Ажлын явцын тайланг Гүйцэтгэгчээс авах;

5.3. Гүйцэтгэгч талын гүйцэтгэж буй гэрээт ажил, бусад дагалдах ажилд хяналт тавьж, цаг тухайд нь шалгах, шаардлага тавих;

5.4. Гүйцэтгэгч талын үйл ажиллагааны алдаа, зөрчлүүдийн улмаас үүсэн гарсан аливаа хохирлыг нөхөн төлүүлэх, гэрээт ажлын тайлан, дүгнэлтийн хувьд гарсан бүх алдаа, зөрчлийг үнэ төлбөргүй дахин боловсруулуулах, шинэчлүүлэх талаар шаардлага тавих;

5.5. Шаардлагатай тохиолдолд гэрээт ажлын гүйцэтгэлд нарийн мэргэжлийн байгууллагаар хөндлөнгийн хяналт, шалгалт хийлгэх;

5.6. Гүйцэтгэсэн ажилд ямар нэгэн доголдол байвал ажил хүлээн авснаас хойш __ жилийн дотор гомдлын шаардлага гаргах эрхтэй.

5.7. Захиалагч нь энэхүү гэрээнд заасны дагуу гэрээний төлбөрийг Гүйцэтгэгчид хугацаанд нь төлөх;

5.8. Гэрээт ажлыг хугацаанд нь гүйцэтгэхэд өөрсдийн зүгээс шаардлагатай туслалцааг Гүйцэтгэгч талд үзүүлэх;

5.9. Энэхүү гэрээнд заасан бусад эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

6. Гүйцэтгэгчийн эрх, үүрэг

6.1. Гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлэхийг Захиалагчаас шаардах;

6.2. Гэрээнд заасны дагуу гэрээний төлбөрийг хүлээн авах;

6.3. Захиалагч талаас гаргаж өгөх судалгааны ажлын хүрээн дэх мэдээ материалыг боломжит цаг хугацаанд нь шаардан авах;

6.4. Гэрээнд заасан ажлыг хугацаандаа чанарын өндөр түвшинд гүйцэтгэн, хүлээлгэн өгөх;

6.5. Гэрээт ажлыг биечлэн гүйцэтгэх;

6.6. Гэрээт ажлын үр дүн, тайлан дүгнэлтийг холбогдох эрх бүхий байгууллагаар нь хянуулан, баталгаажуулуулах;

6.7. Гэрээт ажлын үр дүн, тайлан дүгнэлтэд тусгагдсан норматив болон тооцооны үзүүлэлтүүдийн үнэн зөвийг бүрэн хариуцах;

6.8. Гэрээт ажилтай холбогдсон алдаа, зөрчил бий болсон тохиолдолд Захиалагчид дахин үнэ төлбөргүйгээр засч өгөх, хохирлыг барагдуулах;

6.9. Төмөр замын, замын дээд бүтцийн барилга угсралтын ажлын төсвийн жишиг норм боловсруулж, Зам, тээврийн хөгжлийн яамны Шинжлэх ухаан технологийн зөвлөлөөр дэмжүүлэн батлуулах үүрэгтэй.

6.10. Энэхүү гэрээнд заасан бусад эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

7. Талуудын хариуцлага

7.1. Талууд энэ гэрээнд заасан үүргээ хугацаандаа гүйцэтгээгүй бол ийнхүү хугацаа хэтрүүлсэн хоног тутам гүйцэтгээгүй үүргийн гүйцэтгэлийн үнийн дүнгийн 0,1 хувьтай тэнцэх хэмжээний алданги хүлээнэ.

7.2. Аль нэг тал нь гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн, гэрээнд заасны дагуу нэг талын санаачилгаар гэрээг цуцалсан бол буруутай тал нөгөө талд учруулсан аливаа хохирол болон зардлыг нөхөн төлнө.

7.3. Энэхүү гэрээгээр Гүйцэтгэгч (Н07507296 тоот регистрийн дугаартай Базарбиднаа овогтой Баярсайхан, тоот регистрийн дугаартай овогтой, тоот регистрийн дугаартай овогтой, 4А 76072814 тоот регистрийн дугаартай Ваня овогтой Санжаажав нар) нь Захиалагчийн өмнө хамтран хариуцлага хүлээнэ.

8. Бусад

- 8.1. Энэхүү гэрээ нь байгуулсан өдрөөсөө эхлэн хүчин төгөлдөр болно.
- 8.2. Ажил гүйцэтгэх явцад гэрээнд оруулсан аливаа нэмэлт, өөрчлөлт нь зөвхөн бичгээр хийгдэж талуудын гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.
- 8.3. Учруулсан хохирлыг арилгахтай холбогдсон хууль тогтоомжид заасан үндэслэлээр 2 тал харилцан тохиролцож гэрээг хугацаанаас нь өмнө цуцалж болно.
- 8.4. Талууд харилцан хүндэтгэлтэй, бизнесийн ёс зүйг чанд сахиж, гэрээтэй холбоотой аливаа маргаан гарахаас урьдчилан сэргийлж ажиллана.
- 8.5. Энэхүү гэрээг тайлбарлах болон түүний заалтуудыг хэрэгжүүлэхтэй холбогдож гарсан аливаа маргааныг талууд харилцан тохиролцож шийдвэрлэхийг эрхэмлэнэ.
- 8.6. Талууд харилцан тохиролцоонд хүрэх боломжгүй тохиолдолд Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ.

9. Талуудын хаяг

Захиалагч:

"Монголын төмөр зам" ТӨХК-ийн
Гүйцэтгэх захирал





Б.ЦЭНГЭЛ

Гүйцэтгэгч:

Н075072976 тоот регистрийн дугаартай
Базарбиднаа овогтой Баярсайхан

Б.БАЯРСАЙХАН





2019 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн,.....тоот гэрээний хавсралт
19/115108/87

“Төмөр замын, замын далан, газар шорооны ажлын төсвийн жишиг норм” боловсруулах, Зам, тээврийн хөгжлийн яамны Шинжлэх ухаан технологийн зөвлөлөөр дэмжүүлэн батлуулах ажлын хүрээнд доорхи үнийн саналыг хүргүүлж байна.

Нэг. Хүрэх үр дүн

“Төмөр замын далан, газар шорооны ажлын төсвийн жишиг норм” боловсруулсанаар доорхи үр дүнд хүрнэ.

1. Монгол улсын төмөр замын салбарын хэмжээнд замын далан, газар шорооны ажил хийж гүйцэтгэхэд баримтлах жишиг үнэ, ажлын хэмжээ, зардал, төсвийг тооцох аргачлал эрх зүйн бичиг баримт бий болно.
2. Тус норм, дүрэм бий болсоноор шинэ төмөр замын гол шугам, өртөөний замууд, салбар замуудыг шинээр барих, мөн одоо байгаа төмөр замын их засвар, шинэчлэлт, мөн өртөөний замын өргөтгөл шинэчлэлт хийхэд ашиглана.

Хоёр. Хийгдэх ажлууд

1. Автозамын салбарт хэрэглэж байгаа барилгын ажлын төсвийн жишиг нормуудыг судлах
2. Сборники сметных норм и расценок на строительные работы. Сборник 1. Земляные работы нормыг судлах
3. “A planning methodology for railway construction cost estimation in north America” Jeffrey Tyler Von Brown судлаж ашиглах
4. Төмөр замын, авто замын далан, газар шорооны ажил гүйцэтгэж бгаа ажлуудыг газар дээр зураг авалт хийж ажилбаруудын хийж гүйцэтгэх машинт цагийг тогтоосон нормуудтай харьцуулж тооцох (Авто замын барих ажил, Төмөр зам барих ажил гүйцэтгэж бгаа компаниудын хийж байгаа ажлууд)
5. Дээрхи ажлуудын хийж гүйцэтгэсний дараа “Төмөр замын, замын далан, газар шорооны ажлын төсвийн жишиг норм” нэг багц норм дүрмийг боловсруулна.

Гурав. Ажиллах мэргэжилтэн

Д/д	Нэр	Мэргэжил	мэргэшил	Туршлага
1	Л.Вандандавга	Зам барилгын инженер	МУ-ын зөвлөх инженер	Төмөр замын салбарт нийт 40 жил ажилласан Арчлалт засвар, их барилгын чиглэл, норм нормитав
2	Б.Баярсайхан	Зам барилгын инженер	МУ-ын зөвлөх инженер	Төмөр замын салбарт нийт 21 орчим жил ажилласан Арчлалт засвар, их барилгын чиглэл, норм нормитав, зураг төсөл
3	В.Санжаажав	Замын барилгын инженер	Замын мастер	Төмөр замын салбарт нийт 23 орчим жил ажилласан. Арчлалт засвар

Дөрөв. Хугацаа

1. 2 сар